



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/256

Булган сум

Гамшгаас хамгаалах албад  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.9, 32.1.10 дугаар заалт, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 58 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, сумын нутаг дэвсгэрт гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй арга хэмжээг уялдуулан зохицуулах зорилгоор аймгийн гамшгаас хамгаалах шуурхай штабын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, гамшгаас хамгаалах албадыг 2 дугаар, шуурхай штабын ажиллах журмыг 3 дугаар, албадын бүтэц, нийтлэг чиг үүргийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгаас хамгаалах алба нь эрхэлсэн салбарынхаа хэмжээнд шуурхай штаб, мэргэжлийн ангийг байгуулан, гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл бэлэн байдлыг хангаж гамшгийн үед эрхэлсэн салбарын тогтвортой ажиллагааг хангаж ажиллахыг алба, шуурхай штабын дарга нарт, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ш.Баасандорж)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/663 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



04 дүгээр сарын 14-ны өдрийн 256 дугаар  
Аймгийн Засаг даргын 2023 оны  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ШУУРХАЙ ШТАБЫН  
БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Бүтэц	Албан тушаал
1	2	3
1	Аймгийн Шуурхай штабын дарга	Аймгийн Засаг даргын орлогч
2	Сумдын асуудал хариуцсан орлогч	Аймгийн Засаг Даргын Тамгын газрын дарга
3	Ажиллагаа хариуцсан орлогч	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан дарга сэргийлэх тасгийн дарга
4	Холбогчид	Онцгой байдлын газрын ЭХАС-ын дарга, Цэргийн штабын дайчилгааны офицер
5	Хэвлэл мэдээлэл	Аймгийн ЗДТГ-ын ХМОНХА-ны дарга, "Сайхан Монгол" телевизийн захирал
6	Аюулгүй байдал	Цагдаагийн газрын НХЖХТ-ийн дарга, Тагнуулын хэлтсийн Мэдээлэл аюулгүй байдлын ахлах ажилтан
7	Хяналт	Онцгой байдлын газрын ГХТББХАМ, ГХУХБ, Цагдаагийн газрын НХЖХТ-ийн ахлах байцаагч



Аймгийн Засаг даргын 2023 оны  
 04 дүгээр сарын 14-ны өдрийн А/256 дугаар  
 захирамжийн 2 дугаар хавсралт



АЖИЛЛАГААНЫ БАГ

Д/д	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн ахлагч	Бүрэлдэхүүний тоо
1	2	3	4
<b>Нэг. Ажлын хэсгийн бүтэц</b>			
1	Хүч хэрэгслийг нэгтгэн удирдах, газар хөдлөлтийн аюултай тэмцэх ажлын хэсэг	Аймгийн Засаг даргын орлогч	13
2	Үер, хөдөлтийн аюултай тэмцэх ажлын хэсэг	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	10
3	Объектын болон Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлын хэсэг	Онцгой байдлын газрын дарга	9
4	Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөрний үед ажиллах ажлын хэсэг	Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга	9
5	Хүний гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг	Эрүүл мэндийн газрын дарга	7
6	Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг	Мал эмнэлгийн газрын дарга	7
7	Үйлдвэрлэлийн осол, химийн бодисын аюултай тэмцэх ажлын хэсэг	АЗДТГ-ын Цэргийн штабын дарга	7
8	Эрчим хүчний эрсдэлтэй тэмцэх ажлын хэсэг	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	5
<b>Хоёр. Хүч хэрэгслийг нэгтгэн удирдах, газар хөдлөлтийн аюулын үед ажиллах ажлын хэсэг</b>			
Албан тушаал, томилгоо			
д/д			
1	Хүч, хэрэгслийг нэгтгэн удирдах, газар хөдлөлтийн аюултай тэмцэх ажлын хэсгийн дарга		
2	Онцгой байдлын газрын дарга		
3	АЗДТГ-ын дарга		
4	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга		
5	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга		
6	Цагдаагийн газрын дарга		
7	Эрүүл мэндийн газрын дарга		
8	Булган аймаг авто тээврийн төвийн дарга		
9	Булган "АЗЗА" ТӨХК-ний захирал		
10	"Булган Мээж" ОНӨХХК		
11	ЭБЦТСТӨХК-ний Булган салбарын дарга		
12	Булган сумын Засаг дарга		
13	АЗДТГ-ын Нийтлэг үйлчилгээний албаны дарга		
<b>Хоёр. Үер, хөдөлтийн аюулын үед ажиллах ажлын хэсэг</b>			
1	Үер, хөдөлттэй тэмцэх ажлын хэсгийн дарга		
2	Онцгой байдлын газрын дарга		
3	Цэргийн штабын дарга		
4	Эрүүл мэндийн газрын дарга		
5	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга		



6	“Булган Мээж” ОНӨХХК-ний захирал
7	Цагдаагийн газрын дарга
8	ЭБЦТСТӨХК-ний Булган аймаг дахь салбарын дарга
9	Булган “АЗЗА” ТӨХК-ний захирал
10	Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
<b>Гурав. Объектийн болон Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлын хэсэг</b>	
1	Объектийн болон Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлын хэсгийн дарга
2	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
3	Цагдаагийн газрын дарга
4	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
5	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
6	Эрүүл мэндийн газрын дарга
7	Булган аймаг авто тээврийн төвийн дарга
8	Булган сумын Засаг дарга
9	Гал түймэр унтраах, аврах 20-р ангийн захирагч
<b>Дөрөв. Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөрний аюулт үзэгдлийн үед ажиллах ажлын хэсэг</b>	
1	Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөрний аюулт үзэгдлийн үед ажиллах ажлын хэсгийн дарга
2	Онцгой байдлын газрын дарга
3	Цагдаагийн газрын дарга
4	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
5	Мал эмнэлгийн газрын дарга
6	Эрүүл мэндийн газрын дарга
7	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
8	“Булган-АЗЗА” ТӨХК-ний захирал
9	ЭБЦТСТӨХК-ний Булган аймаг дахь салбарын дарга
<b>Тав. Хүний гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг</b>	
1	Хүний гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсгийн дарга
2	Онцгой байдлын газрын дарга
3	АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
4	Цагдаагийн газрын дарга
5	ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн дарга
6	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
7	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга
<b>Зургаа. Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсэг</b>	
1	Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хэсгийн дарга
2	Онцгой байдлын газрын дарга
3	Цагдаагийн газрын дарга
4	ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн дарга
5	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
6	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
7	Эрүүл мэндийн газрын дарга
<b>Долоо. Үйлдвэрлэлийн осол, химийн бодисын аюултай тэмцэх ажлын хэсэг</b>	
1	Үйлдвэрлэлийн осол, химийн бодисын аюултай тэмцэх ажлын хэсгийн дарга
2	Онцгой байдлын газрын дарга
3	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
4	Цагдаагийн газрын дарга
5	Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
6	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
7	ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн дарга
<b>Найм. Эрчим хүчний эрсдэлтэй тэмцэх ажлын хэсэг</b>	

1	АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
2	Онцгой байдлын газрын дарга
3	Эрдэнэт-Булган ЦТСүлжээ ТӨХК-ний Булган аймаг дахь салбарын дарга
4	"Булган Мээж" ОНӨХХК-ний захирал

--- оОо ---



## ШТАБЫН БАГУУД


Д/д	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн ахлагч	Бүрэлдэхүүний тоо
1	2	3	4
<b>Нэг. Ажлын хэсгийн бүтэц</b>			
1	Төлөвлөлтийн баг	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	7
2	Санхүү, хангалтын баг	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	7
3	Захиргааны баг	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга	
4	Орон нутаг зохицуулалтын баг	Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	
<b>Хоёр. Төлөвлөлтийн багийн ажлын хэсэг</b>			
Албан тушаал, томилгоо			
1	Төлөвлөлтийн багийн ажлын хэсгийн ахлагч		
2	Онцгой байдлын байдлын газрын гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч		
3	Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдлийн удирдлага, үнэлгээ дотоод ажил хариуцсан мэргэжилтэн		
4	Цагдаагийн газрын эрүүгийн ахлах мөрдөгч		
5	Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн		
6	Автотээврийн төвийн улсын байцаагч		
7	Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн		
<b>Хоёр. Санхүү, хангалтын багийн ажлын хэсэг</b>			
1	Санхүү, хангалтын багийн ажлын хэсгийн ахлагч		
2	ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн		
3	ХХААГ-ын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны мэргэжилтэн		
4	Онцгой байдлын газрын ахлах нягтлан бодогч		
5	Улаан загалмайн хорооны дарга		
6	"Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй" ОНӨХХК		
7	ШТС-ын эрхлэгч нар		
<b>Гурав. Захиргааны багийн ажлын хэсэг</b>			
1	Захиргааны багийн ажлын хэсгийн ахлагч		
2	Онцгой байдлын газрын ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн		
3	ЗДТГ-ын ХЭЗХэлтсийн ахлах мэргэжилтэн		
4	ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан		
<b>Дөрөв. Орон нутаг зохицуулалтын багийн ажлын хэсэг</b>			
1	Орон нутаг зохицуулалтын багийн ажлын хэсгийн ахлагч		
2	Онцгой байдлын газрын ГХТБХАМ, ГХУХБ		
3	ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн		
4	Сумын Засаг даргын орлогч нар		

**ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН НУТГИЙН  
АЛБАД БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах дараах орон нутгийн албад байна.

Д/д	Аймгийн албадын нэр	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4
1	Байгалийн болон цацраг химийн аюулыг үнэлж мэдээлэх алба	Ус, цаг уур орчны шинжилгээний газар	---
2	Эрүүл мэндийн алба	Эрүүл мэндийн газар	---
3	Хүнс, хөдөө аж ахуйн алба	ХХААГ	---
4	Эрчим хүчээр хангах алба	“Эрдэнэт-Булган” ЦТСТӨХК-ний Булган аймаг дахь салбар	---
5	Хэв журам сахиулах алба	Цагдаагийн газар	---
6	Мэдээлэл харилцаа холбооны алба	“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК	Цахилгаан холбоо компани, Үүрэн хобооны операторууд
7	Сурталчилгааны алба	Аймгийн ЗДТГ-ын ХМОНХА	“Сайхан-Монгол” телевиз
8	Мал эмнэлгийн алба	Мал эмнэлгийн газар	
9	Ус, дулаанаар хангах алба	“Булган Мээж” ОНӨХК	“Дулааны станц”
10	Байгаль орчны алба	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	
11	Зам, тээврийн алба	Авто тээврийн үндэсний төвийн Булган аймаг дахь салбар	---
12	Барилга, хот байгуулалтын алба	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	---
13	Уул уурхайн алба	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ	---
14	Хүн, ам нийгмийн хамгааллын алба	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс





## АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын хор уршгийг арилгах арга хэмжээний үед Гамшгаас хамгаалах Шуурхай штаб (цаашид "Шуурхай штаб" гэх) болон салбар хоорондын байгууллагуудын үйл ажиллагааны харилцааг зохицуулахад оршино.

1.2. Штаб нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомж, аюулт үзэгдэл, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, гамшиг, ослын талаарх олон улсын дүрэм, журам, зөвлөмж, аймгийн Онцгой комиссын даргын тушаал шийдвэрийг мөрдлөг болгож ажиллана.

1.3. Штабын бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүнийг Улсын онцгой комиссын дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссын штабын бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг энэхүү журамд нийцүүлэн тухайн шатны Онцгой комиссын дарга батална.

1.4. Штабын үйл ажиллагаанд аймгийн онцгой комиссын нэр бүхий албан бичгийн хэвэлмэл хуудас, тэмдэг ашиглана.

### Хоёр. Штабын удирдлага, зохион байгуулалт, бүтэц

2.1. Гамшиг, аюулт үзэгдэлтэй тэмцэх бодлогыг аймгийн Онцгой комисс удирдаж, өдөр тутмын зохицуулах үйл ажиллагааг Шуурхай штабын дарга чиглүүлэн зохион байгуулна.

Аймгийн Шуурхай штабын дарга нь штабыг бодлого, стратегийн удирдлагаар, штабын орлогч дарга нар нь өдөр тутмын удирдлагаар хангана.

2.2. Штабын өдөр тутмын үйл ажиллагааг штабын дарга удирдан зохион байгуулж хяналт тавина.

2.3. Штабын гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед тогтвортой ажиллах удирдлагын суурь болон хөдөлгөөнт байрлалтай, тус байр нь бүх төрлийн холбооны хэрэгслээр иж бүрэн тоноглогдсон байна.

2.4. Штабын бүрэлдэхүүнд агентлаг, гамшгаас хамгаалах алба, тусгай чиг үүрэг бүхий холбогдох төрийн байгууллагын мэргэшсэн, өндөр ур чадвар бүхий хэлтсийн дарга 1-2 мэргэжилтэн, Улаан загалмай хорооны төлөөллийг ажиллуулна. Гамшиг, ослын хүндэрсэн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан төрийн байгууллагуудаас холбогдох албан тушаалтныг нэмж дайчлан ажиллуулна. Дайчлагдан ажиллаж буй төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, илүү цагийн цалин, хөлсийг хуульд заасны дагуу олгох асуудлыг холбогдох байгууллагад нь уламжилж, хяналт тавьж ажиллана.

2.5. Штабын бүтэц дарга, салбар хоорондын харилцан уялдааг ханган ажиллах орлогч, сумдын асуудал хариуцсан орлогч, холбогч офицер, хэвлэл мэдээлэл, аюулгүй



байдал болон хяналтыг бүлэг, хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажиллагааны, төлөвлөлтийн, хангалтын, санхүү, захиргааны, орон нутаг зохицуулалтын баг (цаашид “Штабын багууд” гэх)-аас бүрдэнэ.

2.6. Штаб нь гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүсээгүй үед идэвхижихгүй. Зөвхөн жижүүрийн бүрэлдэхүүн ажиллана.

2.7. Штабын бие бүрэлдэхүүн хариуцсан салбарын хүч хэрэгслийн мэдээллийг урьдчилан штабын программд оруулсан байна.

2.8. Шаардлагатай тохиолдолд Штабын дэргэд улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, аюулгүй байдлын чиглэлээр мэргэжлийн дэмжлэг үзүүлэх багийг Улсын онцгой комиссын даргын шийдвэрээр түр томилон ажиллуулна.

### **Гурав. Шуурхай штабын бүрэлдэхүүний эрх, үүрэг**

3.1. Штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын хор уршгийг арилгах арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах.

3.1.2. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хор уршгийг арилгахад шаардлагатай бүх төрлийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх.

3.1.3. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын хор уршгийг арилгах чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комиссын Шуурхай штабын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, тайлагнах.

3.1.4. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Улсын онцгой комиссын нэгдсэн шуурхай штаб, бүсийн төвийг мэдээллээр хангах.

3.1.5. Гамшиг, ослын арга хэмжээг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан салбар дундын харилцан ажиллагааг төлөвлөж зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, холбогдох журам, төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжүүлэх.

3.1.6. Тайван цагт штабын бүрэлдэхүүн улиралд 1-ээс доошгүй удаа цугларч, шаардлагатай мэдээлэл солилцох, төлөвлөлт хийх.

3.2. Штабын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.2.1 Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед аймгийн онцгой комиссын даргын шийдвэрээр штабын үйл ажиллагааг зохион байгуулалтад оруулж, удирдах.

3.2.2. Штабын бүтцийн баг, бүлгүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гүйцэтгэлд хяналт тавих.

3.2.3. Штабын бүрэлдэхүүн, сумын штабуудад үүрэг, чиглэл өгөх, биелэлтийг хангуулах хяналт тавих.

3.2.4. Улсын онцгой комиссын нэгдсэн шуурхай штабын шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр Улсын онцгой комисст тайлагнах.

3.2.5. Улсын онцгой комиссын нэгдсэн шуурхай штабын хяналт шалгалтын багийн мэдээлэл, санал, дүгнэлтийг үндэслэн авах арга хэмжээний төлөвлөлтийг хийж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

3.2.6. Улсын онцгой комиссын нэгдсэн шуурхай штабын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүд болон холбогдох албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангах.



3.2.8. Хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч штабын томилгоот бүрэлдэхүүнийг 24 цагаар ажиллуулах, ажлын цагийн зохицуулалт хийх, шаардлагатай бусад зохион байгуулалтын арга хэмжээ авах.

3.2.9. Тайван цагт агентлаг, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн бүх төрлийн нөөцийг судалгааг гаргуулж, тодотгох.

3.2.10. Тайван цагт штабын бүрэлдэхүүнийг улиралд 1-ээс доошгүй удаа цуглуулах, дадлагажуулах, бэлэн байдлыг хангуулах.

3.3. Штабын салбар хоорондын харилцан уялдааг ханган ажиллах орлогч нь гамшиг, гамшгийн онцгой нөхцлийн хор уршгийг арилгах чиглэлээр бүх түвшинд гамшгаас хамгаалах орон нутгийн албад, нутгийн захиргааны байгууллага, Засгийн газрын тогтоолоор баталсан “Онцгой нөхцөл байдал үүссэн үед Төрийн цэргийн байгууллагуудын харилцан ажиллагааг хангах төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулах, салбар дундын харилцан ажиллагааг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, гүйцэтгэлийг хянаж ажиллана.

3.4. Гамшгаас хамгаалах албад, сумдын асуудал хариуцсан орлогч нь аймгийн нутаг дэвсгэрт тохиолдсон гамшиг, гамшгийн онцгой нөхцлийн хор уршгийг арилгах арга хэмжээг штабын үйл ажиллагаатай уялдуулж, мэдээллээр хангаж, зохицуулалтыг шуурхай хийж, удирдлагын багийг штабт ажиллуулж, үйл ажиллагааг нь өдөр тутмын удирдлагаар хангаж, хяналт тавина.

#### **4. Штабын баг, бүлгүүд дараах эрх , үүргийг хэрэгжүүлнэ.**

4.1. Холбогч нь нөхцөлт байдлын болон бүх эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, штабын дарга болон багуудыг мэдээ, мэдээллээр хангах, удирдлагын мэдээллийг тухай бүрт танилцуулна.

4.2. Хэвлэл мэдээллийн бүлэг нь гамшиг,ослын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, штабын үйл ажиллагааг олон нийтэд нэг сувгаар мэдээлэх, худал мэдээ, мэдээллийг хянах, залруулах арга хэмжээг авна.

4.3 Аюулгүй байдлын бүлэг нь штабын хэвийн үйл ажиллагаа, ажлын ачаалал, хөдөлмөр хамгаалал, штабт нөлөөлөх гадаад аюулгүй байдлыг хангана. Штабын бие бүрэлдэхүүнээс программд оруулсан хүч хэрэгслийн талаарх мэдээ, мэдээллийн кибер аюулгүй байдлыг хангаж ажиллана.

4.4 Хяналтын бүлэг нь штабын дотоод үйл ажиллагаа болон хариу арга хэмжээний гүйцэтгэл, гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, Штабын удирдлагыг мэдээллээр шуурхай хангах, шаардлагатай тохиолдолд ажиллагааны багийн удирдамжийн дагуу заавар, зөвлөмж өгнө.

4.5. Ажиллагааны баг нь гамшиг, гамшгийн онцгой нөхцлийн хор уршгийг арилгах чиглэлээр төлөвлөлтийн багаас ирүүлсэн чиглэлийн дагуу гамшиг, ослын голомт дахь ослын удирдагч, хүч хэрэгслийг зохицуулалтаар хангана. Ажиллагааны багийн үйл ажиллагаа тасралтгүй, гэнэтийн үүссэн ослын нөхцөл байдалд уян хатан шуурхай зохицуулалт хийнэ.

4.6. Төлөвлөлтийн баг нь гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын талаар гамшгийн голомт дахь хүч хэрэгслээс мэдээлэл цуглуулах , боловсруулж, эрсдлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээ, нөөцийг хуваарлах арга хэмжээг төлөвлөнө. Үйл ажиллагаандаа Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн



аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө"-г удирдамж болгоно.

4.7. Хангалтын баг нь орон нутгийн бүх төрлийн нөөцийн судалгааг гаргах, нөөцийг захиалах, бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хангалтын багын гишүүд нь өөрсдийн салбарын бодит нөөцийн судалгааг гаргаж, шаардлагатай тохиолдолд бодитоор шалгаж, бэлэн байдлыг хангуулах. Нөөц хүрэлцээгүй болохоос сэргийлж, шаардагдах нөөцийн судалгааг гаргаж УОК болон АОК-т танилцуулах бэлтгэлийг хангана.

4.8. Санхүү, захиргааны баг нь штабын үйл ажиллагаа болон хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, зардлыг төлөвлөх, захиргааны баримт бичгийн бүрдүүлэлт хийх, үйл ажиллагааг баримтуулж, архивлах, 24 цагийн шуурхай жижүүрийн зохицуулалт хийнэ.

4.9. Орон нутгийн баг нь орон нутгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулалт, дүн шинжилгээ хийх, дэмжлэг зохицуулалтаар хангах арга хэмжээг хэрэгжүүлж, штабын үндсэн үйл ажиллагаатай нягт уялдуулна.

#### **Тав. Бусад зүйл**

5.1. Штабын бүрэлдэхүүн нь төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

5.2. Штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гарсан шийдвэр нь Монгол Улсын үндсэн хуулинд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн, иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байна.

5.3. Штаб нь ажлын тусгай горимоор буюу уртасгасан цагаар ажиллах үед штабт үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүнд нэмэгдэл цалин, урамшуулал олгоно.

5.4. Нэмэгдэл цалин, урамшуулал олгох асуудлыг аймгийн Онцгой комиссын дарга шийдвэрлэнэ.

5.5. Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дүгээр сарын 14-ны өдрийн А/256 дугаар  
захирамжийн 4 дүгээр хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАНЫ БҮТЭЦ  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

